

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

2020 оны 4 дугаар улирал

Багануур дүүрэг

№	д/д	Үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	Хүрэх түвшин	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр	Үнэлгээ-ний хувь
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ</b>								
<b>1.1.</b>		<b>1.2. Үйлдвэрлэл, инновацийг цогцоор нь хөгжүүлнэ.</b>						
1	1-4	1.10. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	<b>Заалт:</b> батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг эрчимжүүлнэ.	НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	1. Хүнд үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн асуудлын шийдвэрлэлт хувь	1. (100)	Төр, хувийн хэвшлийн түншлэл	
				НШУУИГ, НХБХГ, БҮТП ОНӨТҮГ	2. Цахилгаан хангамжийн ажлын явц, хувь	2. (50)	9,658.29 Гадаадын эх үүсвэр	
<b>Биелэлт: Шалгуур үзүүлэлт 1.</b> <ul style="list-style-type: none"> <li>2020 онд Паркийн дэд бүтцүүдийг байгуулах хөгжлийн төлөвлөгөөг 2020-2024 оны хугацаагаар боловсруулан бэлтгэл ажлуудыг бүрэн хангаж ажиллаж байна.</li> <li>Хүнд үйлдвэрийн дэд бүтцэд 2020 оны Хөрөнгө оруулалтын төслийг Нийслэл болон улсын төсөвт тусгуулахаар НХОХХ болон УУХҮЯ-д хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй.</li> <li>Хүнд үйлдвэрийн бүс нь Багануур ХК-ийн үйлдвэрлэлийн бүс дотор тэр тусмаа одоогоор ашиглалтгүй байгаа “Породная станция” /110 кв-н дэд станцтай, авто болон төмөр замтай, дулааны шугам, цэвэр усны шугам, бохирын шугамд холбогдсон/ байгууламжийн дэргэд байршилтай учраас тус байгууламжийн дэд бүтцээс урт хугацаагаар ашиглаж болох судалгаа хийж үзэхэд манай талд их хэмжээний зардал хэмнэх, Багануур ХК-ийн талд Паркийн үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлэх, хамтран ажиллах замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэж дүгнэсэн. Энэ тухай НШУУИГ-аар уламжлан НЗД-ын зөвлөлийн хуралд оруулахаар санал хүргүүлсэн.</li> <li>Тус зөвлөлийн хурлаас ажлын хэсэг байгуулан ажиллах шийдвэр гаргавал Багануур ХК, тус компанийн ТУЗ, УУХҮЯ-тай хэлэлцэж шийдвэрлэх бүрэн боломжтой байна.</li> </ul>								

## Шалгуур үзүүлэлт 2.

- БХБЯ-ны захиалгаар “Мон – Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажлын цахилгаанаас бусад хэсгийг иж бүрэн дуусгаж тус яамны хяналт магадлангаар баталгаажуулагдсан.
- Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 7,3 км урт 110 Кв-н өндөр хүчдэлийн агаарын шугам 110/35/10 Кв-ын дэд станцын хамт нэн тэргүүнд байгуулах шаардлагатай байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын төслийг Нийслэл болон улсын төсөвт тусгуулахаар НХОХХ болон ЭХЯ-д хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Гадаадын тодорхойгүй эх үүсвэрээр санхүүжүүлэхээр Нийслэлийн ЭЗН-ыг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан.
- Багануурт арматур төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа “МЕСЕС” ХХК нь 17 мВт эрчим хүч үйлдвэртээ татах техникийн нөхцөл авсан боловч трасс газаргүй тул БҮТП-ийн батлагдсан трассыг ашиглан хамтарсан хөрөнгө оруулалтаар дээрх 7,3 км ӨХАШ-ыг барих санал 2020 оны 02 дугаар сард манайд тавьсан. Учир нь тус үйлдвэрийн байршил манай паркийн Хөнгөн болон Хүнсний үйлдвэрийн бүстэй зэргэлдээ байршилтай байна.
- Тус компанийн саналыг нарийвчлан судалж үзсэний дүнд харилцан ашигтай тул НЗД асан С.Амарсайхан болон Багануур дүүргийн засаг дарга асан Ц.Сандаг-Очир нарт танилцуулж үүрэг чиглэл авч өнөөдрийг хүртэл ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
  1. “МЕСЕС” ХХК-тай Хамтран ажиллах гэрээ байгуулав. /2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр/
  2. Талуудын цахилгаан эрчим хүч ашиглах Техникийн нөхцөлүүдийг нэгтгэх төслийг боловсруулан ЦДҮС ТӨХК-д хандаж мэргэжлийн зөвлөмж гаргуулав. /2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр/
  3. Дээрх зөвлөмжийг үндэслэн ЭХЯ-ны Диспетчерийн үндэсний төвд хандаж тооцоолол хийлгэж дүгнэлт гаргуулав. /2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр/
  4. ДҮТ-ийн дүгнэлтийг үндэслэж нэгдсэн техникийн нөхцөл авах хүсэлтийг ЭХЯ-д хүргүүлж /2020 оны 08 дугаар сарын 10-ны өдөр №51/2020/87 тоот техникийн нөхцөл хүлээж авав./
  5. Нэгдсэн шинэ техникийн нөхцөлөөр трассын газрыг Багануур дүүргийн Газрын алба болон бусад дэд бүтцийн байгууллагатай зөвшилцөж баталгаажуулав.
  6. 2020.08.12-ны Шинэ техникийн нөхцөлийг үндэслэн Паркийн зураг төслийг захиалагч БХБЯ болон Гүйцэтгэгч “Мон-Энержи” ХХК, гэрээнд шууд хяналт тавьж ажиллаж байгаа “Барилга хөгжлийн төв”-ийн талуудтай зөвлөгөөн зохион байгуулж, ерөнхий цахилгаан хангамжийн 110 Кв-ын зураг схемийг дэд станцын хамтаар, цаашлаад ерөнхий дэд станцаас Паркийн бүх бүсүүдийн төлөвлөгдсөн үйлдвэр бүрт хүрэх гадна болон дотоод цахилгаан хангамжийн зураг төслийг иж бүрэн шинэчлэн боловсруулахаар шийдвэрлэж, гүйцэтгэлийг эхлүүлэв.
  7. Техникийн нөхцөлөөр ажлын зургийн даалгаврыг ЭХЯ-д 2020.09.10 өдөр шийдвэрлүүлэн батлуулав.
- “МЕСЕС” ХХК нь трассын дагуу геологийн шинжилгээний ажлыг эхлүүлсэн.
- БҮТП ОНӨТҮГ-аас хариуцах хөрөнгө оруулалтыг нийслэлийн төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх санал төслийг НЗД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батбаясгаланд холбогдох материалуудын хамт /2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 154 тоот албан бичгээр хүргүүлээд байна.

		<ul style="list-style-type: none"> <li>• Энэхүү хамтарсан хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжсэнээр ерөнхий цахилгаан хангамжийн 7,3 км ӨХАШ барих төсөвт зардал 2,1 тэрбум төгрөгөөр хэмнэгдэж байна.</li> <li>• 7,3 км ӨХАШ нь баригдаж дуусмагц 100% БҮТП-ийн өмчид шилжинэ.</li> </ul>	
		<p><b>Үр дүн, үр нөлөө:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Багануур ХК-ийн ашиглагдаагүй дэд бүтцийг ашиглах урт хугацааны гэрээ байгуулснаар паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх бөгөөд энэ нь тус дэд бүтцийг байгуулахад шаардлагатай их хэмжээний санхүүжилт болон цаг хугацааг хэмнэнэ.</li> <li>2. Өндөр хүчдэлийн 110 кВ-ийн шугамтай болсноор цаашид 2*25000 мВа-ын дэд станц байгуулах техникийн нөхцөлийг бүрдүүлнэ. Энэхүү дэд станц нь БҮТП-ийн нийт цахилгаан хангамжийг түгээх үндсэн эх үүсвэр болно.</li> </ol>	
		<b>Дундаж хувь</b>	<b>75%</b>

БИЕЛЭЛТ ХЯНАСАН  
 БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
 ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:  
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Э. Энхзаяа*

Э.ЭНХЗАЯА